

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралт

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

2018.12.20

Улаанбаатар хот

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|--------------------------|---|---|--|---|
| 1 | 2 | 3 | 4 | | 6 |
| 1.6.Улсын Их Хурлын тогтоол | | | | | |
| “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 2016.11.03 Дугаар 2016_51 | 2 | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авилгатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | НҮГ-ын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, уг төлөвлөгөөний хүрээнд 2018 онд дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд: - Авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээг мэдээллийн самбарт тухай бүр байршуулан газрын ажилтан, албан хаагчдад авилгын эсрэг хууль тогтоомжийг сурталчилан ажиллаж байна. - Нээлттэй ажлын байрны мэдээлэл, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг Нийтлэг үйлчилгээний газрын www.khangardi.mn цахим систем болон байгууллагын ил тод байдлын самбарт тогтмол байршуулан нийтэд мэдээлж буй болно. Мөн | 100% | |

| | | | | | |
|--------------------------|--|--|---|--|--|
| | | | <p>нээлттэй ажлын байрны мэдээллийг зарын нэгдсэн сайт www.unegui.mn байршуулахын зэрэгцээ дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст захиалга өгч байна.</p> <ul style="list-style-type: none"> - 2018 онд НҮГ-ын Захиргаа, санхүүгийн хэлтэст шинээр ажилд орсон 8 ажилтны ХАСУМ-ийг Авилгатай тэмцэх газарт илгээж, тус газраас ирүүлсэн хариуг үндэслэн ажиллаж байна. - Бид авилгатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжтэй танилцаж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаж буй бөгөөд өнөөдрийн байдлаар 1 албан хаагчийн талаар гомдол ирснийг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, ажлаас чөлөөлсөн. - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтад манай байгууллагын 46 албан хаагч хамрагдсан болно. - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, тайланг сар бүрийн 01-ний өдрийн дотор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллаа. - “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажлын тайлан мэдээг тогтоосон хугацаанд НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэн ажиллаж байна. | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |

1.в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

1.г.Ерөнхийлөгчийн зарлиг

| | | | | | |
|--|---|--|---|------|--|
| <p>“Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай” 2018.04.11 Дугаар 2018_38</p> | 3 | <p>Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж, түгээн дэлгэрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдэд уриалсугай.</p> | <p>НҮГ-ын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө нь 2018.01.08-ны өдөр батлагдсан ба уг төлөвлөгөөний хүрээнд “Хуулиар хүлээсэн үүрэг, удирдлага зохион байгуулалт, авлигатай тэмцэх санал санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх” чиглэлээр 5 арга хэмжээ, “Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт” чиглэлээр 4 арга хэмжээ, “Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, шударга ёс, ил тод байдлыг хангах” чиглэлээр 2 арга хэмжээ, нийт 11 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээр төлөвлөгөөт ажлын биелэлтийн талаар Улсын Их Хурлын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хэсэгт дэлгэрэнгүй дурдсан болно.</p> | 100% | |
| | 4 | <p>Авилгаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жилийн хүрээнд бүх нийтээр авлигыг үл тэвчин, тухай бүр илчилж, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэхийн төлөө нягт хамтарч, нэгнээ дэмжин ажиллахыг иргэддээ уриалсугай.</p> | <p>Авилгаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жилийн хүрээнд байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад авлигыг жигших, авлигаас ангид байх үзлийг төлөвшүүлэх зорилгоор тодорхой арга хэмжээ авч ажилласан бөгөөд ийнхүү хэрэгжүүлсэн ажлын талаар Улсын Их Хурлын 2016 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 51 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хэсэгт дэлгэрэнгүй дурдсан болно. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ажилтан, албан хаагч бүрт авлигын сөрөг нөлөө, үр дагаврын талаар</p> | 100% | |

| | | | | | |
|--|-----|--|---|------|--|
| | | | мэдлэг, мэдээлэл олгож, авлигыг жигших, авлигаас ангид байх ухамсрыг төлөвшүүлэх ач холбогдолтой юм. | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| 1.д.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл | | | | | |
| 1.е.Засгийн газрын тогтоол | | | | | |
| 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай 2018.01.31 Дугаар 2018_32 | 2 | “Хариуцлагын жил”-ийн хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж, тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан газрын хэмжээнд 2018 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн мэдээ тайланг улирал бүрийн сүүлийн 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цаасан суурьтай болон цахим хэлбэрээр хүргүүлж ажиллалаа. | 100% | |
| | 2.2 | Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн | <ul style="list-style-type: none"> - Удирдлагын зүгээс байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд байнга хяналт тавин, аливаа зөрчил, дутагдал гаргахаас сэргийлэн ажиллаж буй бөгөөд тайлант хугацаанд 62 зөрчил нь бүртгэгдсэн нь өмнөх жилийн мөн үеийнхээс 50 хувь буурсан үзүүлэлттэй байна. - Тайлант хугацаанд тус байгууллагад нийт 230 өргөдөл ирсэн байх ба эдгээр өргөдлийг 100 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргасан этгээдэд биечлэн хүргүүлснээр хугацаа хэтэрч шийдвэрлэсэн зөрчил огт гаргаагүй болно. | 95% | |

| | | | | | |
|--|-----|--|--|------|--|
| | | үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах | - Өргөдөл гомдол хүлээн авсан албан хаагчийн зүгээс явцын тэмдэглэлийг 7 хоног бүр хөтлөн, өргөдөл гаргагчид мэдээлэл өгч, өргөдлийг шуурхай шийдвэрлэн төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулахад тогтмол анхаарал хандуулан ажиллаж байна. | | |
| | 2.3 | Төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх | <ul style="list-style-type: none"> - НҮГ-ын хэмжээнд нийт 1 ажилтан үр дүнгийн гэрээ, бусад ажилтан, албан хаагч хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажил үүргээ гүйцэтгэж байгаа билээ. - Төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас жилээр дүгнэж, тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлсэн ба бүтэн жилийн ажлын дүн мэдээг нэгтгэн дүгнэх ажил 90 хувьтай хэрэгжиж байна. - Тус газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлт буюу хэрэгжүүлсэн ажлын дэлгэрэнгүй тайланг улирал бүр цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, үйлчилгээ техникийн ажиллагсдын хөдөлмөрийн гэрээний биелэлт, ажлын ур чадварыг улирал бүр ажлын байран дээр нь очиж шалган дүгнэсэн. - Ажилтан, албан хаагчдын ур чадварыг хөдөлмөрийн гэрээний хэрэгжилт, тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт, үйлчилгээний ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг баримталж буй байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр дүгнэн, ажилтан, албан хаагч бүрд олгох ур чадварын нэмэгдлийн хэмжээг Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаас хэлэлцэн баталж байна. | 100% | |

| | | | | | |
|--|-----|---|---|------|--|
| | 2.5 | “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах. | <ul style="list-style-type: none"> - Монгол улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд нийцүүлэн НҮГ-ын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээг сарын бүрийн 05-ны өдрийн дотор, албан даалгаврын биелэлтийн мэдээг улирал бүр гаргаж, цаасан суурьтайгаар НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. | 100% | |
| | 4 | “Хариуцлагын жил”-ийн хүрээнд иргэн бүр хууль тогтоомжийг судлан мөрдөж, хувь иргэний эрх, үүргийг нийтийн эрх ашиг, үндэсний язгуур ашиг сонирхолтой зөв хослуулах замаар байгаль орчноо хайрлан хамгаалах болон эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод хувь нэмэр оруулж ажиллахыг уриалсугай. | <ul style="list-style-type: none"> - Эрхэлсэн ажил, оршин суугаа баг, хорооныхоо хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтод НҮГ-ын зүгээс хувь нэмрээ оруулах зорилгоор үйлчилгээ, техникийн ажиллагсдын дунд хариуцсан засаг захиргааны байрыг өөрийн нөөц боломжийг ашиглан тохижуулах, сэргээн засварлах, шинэ бүтээл, оновчтой санаа гаргах чиглэл бүхий “Эрүүл, тохилог ажлын байр” сэдэвт болзолт уралдаан зарласан. Уг болзолт уралдаанд нийт 17 баг оролцож, НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5А, 5Б, 5В байр болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудыг өөрсдийн нөөц боломжоор тохижуулж, сэргээн засварлах ажлууд хийгдсэн. - Нийслэлийн засаг захиргааны байруудад хугацаат их цэвэрлэгээг хуваарийн дагуу 226 удаа зохион байгуулж, 5 байрны 15000 м.кв талбайд мэргэжлийн эрх бүхий компаниар ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн болно. - НЗЗ-ны бүх байруудын дотор болон гадна фасадны гэрэлтүүлгийн жигд ажиллагааг хангах, гэрлийг нь | 100% | |

| | | | | | |
|---|-----|--|--|------|--|
| | | | <p>ашиглалт урттай бага цахилгаан эрчим хүч зарцуулдаг лед гэрлээр сольж, хаяг рекламн гэрэлтүүлгийг цагийн релегээр удирдах ажиллагааг жигдрүүлж хийснээр цахилгаан эрчим хүчний зарцуулалтыг 20 хувь бууруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Хангарди ордны нөөц тэжээл болох дизель генераторыг автомат горимд шилжүүлэн АВР сэлгэн залгагчийг бүрэн засварлаж, туршилтын тохируулгыг хийсэн. Мөн ордны үүдэнд 3 ширхэг агаарын тенз байрлуулан цахилгаан схемд холбов. - Хавар, намрын улиралд зохион байгуулагдсан “Үндэсний мод тарих өдөрлөг”-т давхардсан тоогоор тус газрын 560 гаруй ажилтан, албан хаагч идэвхи санаачилгатай оролцож, байгаль орчноо хайрлан хамгаалахад хүн нэг бүрийн хувь нэмрийг оруулан ажиллалаа. | | |
| <p>Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай</p> <p>2018.08.22 Дугаар 2018_258</p> | 1.1 | <p>Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх</p> | <ul style="list-style-type: none"> - Хариуцсан ажил үүрэгтээ хайнга хариуцлагагүй хандсан, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан нийт 17 ажилтанд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал болон Ёс зүйн зөвлөлийн хурлаас сахилгын шийтгэл ногдуулах санал гарч 8 ажилтан, албан хаагчид сануулах, 6 ажилтан, албан хаагчид үндсэн цалинг гурван сар хүртэлх хугацаагаар бууруулах, 3 ажилтан, албан хаагчийг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авсан. - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг хагас, бүтэн жилээр гарган НЗДТГ-ын ТЗУХ-т | 100% | |

| | | | | | |
|-----|---|--|--------------------------|--|--|
| | | | хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 1.2 | Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх | <ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчид болон иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр хүлээн авч, www.smartcity.mn цахим системд бүртгэн, удирдлагад танилцуулж, 10 хоног тутам явцын тэмдэглэл хөтөлж, шийдвэрлэгдсэн өргөдөл гомдлын хариуг сайтад байршуулан ажиллаж байна. - 2018 онд нийт 230 өргөдөл гомдол ирснийг 100 хувь шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан ба мөн хугацаанд хугацаа хэтэрсэн болон хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. - Газрын хэмжээнд 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 23 цаг 37 минут байгаа нь өмнөх саруудын дундаж хугацаанаас тогтмол буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 100% | | |
| 1.3 | Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах | Ажилтан, албан хаагчдын гүйцэтгэх чиг үүргийн давхардал, хийдлийг арилгахад тогтмол анхааран ажиллаж буй бөгөөд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтан болон удирдлагын зүгээс ажилтан, албан хаагч нэг бүрийн ажлын бүтээмжийг шалгаж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад анхааран ажиллаж байна. | 100% | | |
| 1.4 | Төрийн жинхэнэ албан | Тус газрын даргаас бусад ажилтан, албан хаагчид нь | | | |

| | | | | | |
|--|-----|--|---|------------------|--|
| | | тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх | Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан үйлчилгээний албаны ангилалд хамаарах тул уг заалтын биелэлтийн мэдээг гаргах боломжгүй юм. | Үнэлэх боломжгүй | |
| | 1.5 | Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа удирдах албан тушаалтнуудын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтын дагуу удирдах албан тушаалтныг томилох; | Манай байгууллага нь төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага тул газрын удирдлагаас бусад ажилтан, албан хаагчид нь Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан үйлчилгээний албан тушаалд багтдаг. Иймд мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалт өгдөггүй тул уг заалтыг цаашид хяналтаас хасуулах саналтай байна. | Үнэлэх боломжгүй | |
| | 1.6 | Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон | Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа 15 ажилтан, албан хаагч, 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж 1 албан хаагч, эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 4 ажилтан, албан хаагч, нийт 23 ажилтан, албан | 100% | |

| | | | | | |
|--|-----|--|--|------|--|
| | | тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | хаагчтай хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. | | |
| | 1.7 | Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлд ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хэрэглэсэн үедээ ирсэн болон ажил үүрэг гүйцэтгэсэн, мөн галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг ажлын байранд нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хатуу хориглож, ийм үйлдэл гаргасан ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Ажил олгогчийн санаачилгаар шууд цуцлахаар тусгасан болно. Тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил бүртгэгдээгүй бөгөөд ажилтан албан хаагч бүр Засгийн газрын тогтоол 258 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 03 дугаар албан даалгавар, газрын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|--|------|---|--|------|--|
| | 1.8 | Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах | Ажилтан, албан хаагчийн гаргасан ёс зүйн зөрчлийг байгууллагын Ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж, тухай бүр зохих арга хэмжээ авч ажиллалаа. Үүний үр дүнд 2018 оны эхний хагас жилд 14 ажилтан, албан хаагчийн ёс зүйн зөрчил бүртгэгдсэн бол сүүлийн хагас жилд энэ тоон мэдээ 3 болж, эхний хагас жилийн мэдээнээс 5 дахин буурсан эерэг үзүүлэлттэй байна. | 100% | |
| | 1.9 | Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах | Ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр байнга бүртгэж, ажлын цаг ашиглалтад 7 хоног бүр хяналт шалгалт хийж, дүнг Газрын шуурхай зөвлөгөөнд танилцуулан ажиллаж байна. Мөн ажилтан, албан хаагчид ажлын байранд үүрэгт ажлаа чанартай үр дүнтэй гүйцэтгэж буй эсэхэд Дотоод хяналт–шинжилгээ, үнэлгээний ажилтнаас тогтмол хяналт тавин ажиллаж буй болно. | 100% | |
| | 1.10 | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах | Газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйл, Ёс зүйн журмын 3, 4 дүгээр зүйлд хууль бус дарамт шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа давтан гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан бөгөөд тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил бүртгэгдээгүй болно. Цаашид хамт олны нийтэч, эерэг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдсэн байдлыг хадгалахад удирдлагын зүгээс анхаарч ажиллана. | 100% | |

| | | | | | |
|--|---|---|---|------|--|
| | 3 | <p>Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж ажиллахыг Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт даалгасугай.</p> | <p>Дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтны зүгээс тайлант хугацаанд нийт 9 удаа хяналт шалгалт зохион байгуулж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг илрүүлэн, дүн мэдээг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулж ажиллаа. Хяналт шалгалтыг газрын даргын 2018.03.20-ны өдөр баталсан “Инженерийн байгууламжийн ашиглалтад дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”, 2018.04.20-ны өдөр баталсан “Цэвэрлэгээ үйлчилгээний стандартад дотоод хяналт шинжилгээг зохион байгуулах удирдамж”, 2018.05.08-ны өдөр баталсан “Зоогийн газар, цайны газруудад дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”, 2018.08.06-ны өдөр баталсан “Дээд газрын тогтоол шийдвэр, захирамж, албан даалгаврын тус газрын чиг үүрэгт хамааралтай заалтуудын биелэлтэд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”, 2018.08.30-ны өдөр баталсан “НҮГ-ын зоогийн газар, цайны газруудад эрүүл ахуй, хоол үйлдвэрлэл, түүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж” 2018.10.01-ний өдөр баталсан “НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээний стандартын хэрэгжилт, аюулгүй ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”, 2018.10.22-ны өдөр баталсан “Байр ашиглалтын албаны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”-ийн дагуу тус тус зохион байгууллаа. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, сайшаалтай талуудыг тэмдэглэн авч, газар дээр нь боломжит байдлаар</p> | 100% | |
|--|---|---|---|------|--|

| | | | | | |
|---|---|---|--|------|--|
| | | | шийдвэрлэхийн зэрэгцээ зарим асуудлыг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. Зөвлөлийн хурлаас зөрчил дутагдлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэн, богино хугацаанд, чанартай байдлаар шийдвэрлэж, эргэн танилцуулахыг хариуцсан алба, хэлтсийн дарга нарт даалгалаа. | | |
| Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018.05.23 2018_138 | 2 | Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг ЗГ-ын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй. | Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоол, Засгийн газрын 2018.04.04-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/509 дүгээр захирамжийг тус тус байгууллагын ажилтан, албан хаагчдад танилцуулан, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг 100% ханган ажиллаж байна. Цаашид тус газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн нийт албан хаагч төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэн, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх боломжийг байнга эрэлхийлэн ажиллана. | 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |

1.ё.Ерөнхий сайдын захирамж

1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл

| | | | | | |
|--|-----------------|--|---|-------------|--|
| <p>2018.04.04-ний өдрийн 16 дугаар тэмдэглэл</p> | <p>ХҮ 2</p> | <p>Ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч ажиллах</p> | <p>Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоол, Засгийн газрын 2018.04.04-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ажлын байранд ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглосноор албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжирсан.</p> | <p>100%</p> | |
| <p>2018.05.16-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл</p> | <p>ХХИХ.2.3</p> | <p>Бодлогын баримт бичгийн зорилт, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга барилыг оновчтой ашиглан бодитой, хэрэгцээт мэдээллээр удирдлага, дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг</p> | <p>Газрын даргын баталсан удирдамжийн дагуу байгууллагын үйл ажиллагаанд тайлант хугацаанд 9 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүн мэдээг газрын даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулсан. Ингэснээр байгууллагын удирдлагуудыг үнэн бодитой, батлагдсан, хэрэгцээт мэдээллээр цаг алдалгүй хангаж, байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тухай бүр арга хэмжээ авч шийдвэрлэн ажилласан болно. Мөн хяналт шалгалтын талаарх тайлан мэдээг сар, улирлаар бэлтгэн НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлж, байгууллагын үйл ажиллагааны талаар хэрэгцээт мэдээллээр дээд шатны байгууллагыг хангахад анхаарч ажиллаж байна.</p> | <p>100%</p> | |

| | | | | | |
|---|----------|---|---|------|--|
| | | дарга нарт даалгав. | | | |
| | XXIX.2.4 | Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав. | Тус газар нь Монгол улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажил үүргээ гүйцэтгэн, төлөвлөгөөний биелэлтийг сарын бүрийн 05-ны өдөр НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. Албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг удаашруулсан, хариуцлагагүй хандсан ажилтан, албан хаагчид холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн хариуцлага тооцон ажиллаж буй болно. | 100% | |
| 2018.08.29-ний өдрийн 36 дугаар тэмдэглэл | XIY.1 | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. | <ul style="list-style-type: none"> - 2018 онд нийт 230 өргөдөл гомдол ирснийг 100 хувь шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан ба мөн хугацаанд хугацаа хэтэрсэн болон хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. - Газрын хэмжээнд 2018 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 11 цаг 25 минут байгаа нь 2017 оны мөн үеийнхтэй харьцуулбал 2 хоног 7 минутаар, өргөдөл гомдлын хандалтын тоо 21 хувиар буурсан байгаа нь манай байгууллагын үйлчилгээ илүү түргэн шуурхай болж, үүссэн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж буйтай холбоотой гэж дүгнэж байна. | 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |

1.3.Засгийн газрын албан даалгавар

| | | | | | |
|--|-------|---|--|------|--|
| Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2017.10.26 дугаар 2017_01 | 1.1.1 | Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх, Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нийт ажилтан, албан хаагчдад сурталчлан таниулах зорилтын хүрээнд байгууллагын удирдлагуудын зүгээс нийт ажилтан, албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахин, мэргэжлийн ур чадвартай ажиллахыг үлгэрлэн ажиллаж байна. | 100% | |
| | 2.2.1 | Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах | Улсын их баяр наадам, Даншиг наадам-Хүрээ цам 2018 болон бусад гэнэтийн үйл ажиллагаанд давхардсан тоогоор 200 орчим ажилтан, албан хаагч хээрийн үйлчилгээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, 8 болон 10 ханатай гэр, үйлчилгээний 5 ханатай гэр, зөөврийн сууц, асар барих, үйл ажиллагаанд уригдсан 600 гаруй зочид төлөөлөгчдөд зоогийн үйлчилгээ, хүлээн авалтын үйлчилгээг үзүүлэх ажлыг мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэлээ. Мөн Хангарьд ордны 15 давхрын зоогийн газар, 16 давхрын хүндэтгэлийн танхимд болсон 70 гаруй хүндэтгэлийн хүлээн авалтыг зохион байгуулж, 3505 зочдод үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ 15 удаагийн хурлын цай, завсарлагаагаар 1500 хүнд үйлчилсэн байна. Дээрх үйлчилгээний үеэр ажилтан, албан хаагч бүр үйлчилгээний ажилтны ёс зүйг чанд баримтлан, түргэн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлэхийг зорин ажиллалаа. | 100% | |

| | | | | | |
|--|-------|---|---|------------------|--|
| | 4 | Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж байна. | НҮГ-ын үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг нь төрийн албан хаагчийн ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход чиглэх учир иргэдээс манай байгууллагад хандсан өргөдөл, гомдол ирдэггүй болно. Иймд уг заалтыг цаашид хяналтаас хасуулах саналтай байна. | Үнэлэх боломжгүй | |
| | 5.1.2 | Авлигын хяналтыг сайжруулах, Төрийн албыг хувийг ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүрт нь таслан зогсоож, авлига, хэзээ хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх | Энэхүү зорилтот ажлын хүрээнд манай байгууллага авлигын эсрэг хууль тогтоомж, зохион байгуулж буй арга хэмжээг мэдээллийн самбарт байршуулан газрын ажилтан, албан хаагчдад авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиллаж байна. Мөн тайлант хугацаанд 1 албан хаагчийн талаар ирсэн гомдлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, ажлаас чөлөөлсөн. | 100% | |
| | 5.1.3 | Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх, “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн, дутагдал | Төрийн албан хаагчдаа сонсож, байгууллагын үйл ажиллагааг дүгнэх үүднээс 2018.11.27-ны өдрөөс 2018.11.30-ны өдрүүдэд “Таныг сонсоё” аян Нийслэлийн засаг захиргааны 5 байр, нийслэлийн үйлчилгээний 3 төвд зохион байгуулсан. Аяны үеэр нээлттэй саналын хуудсаар болон урьдчилан бэлдсэн саналын хуудсаар нийт 500 орчим албан хаагчаас санал асуулга авсан. Мөн хугацаанд газрын хэмжээнд | 100% | |

| | | | | | |
|--|-------|--|---|------|--|
| | | гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүх хариуцлага тооцож ажиллах | нийт 230 өргөдөл гомдол ирснийг нягтлан шалгаж, асуудлыг тухай бүр шийдвэрлэсэн байх үүнээс иргэний талд шийдвэрлэсэн 212, боломжгүй тухай хариу өгсөн 13, бусад хариу өгсөн 6 байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг талаарх мэдээг Засгийн газрын 32 дугаар тогтоол болон 258 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлангийн хэсэгт дэлгэрэнгүй дурдав. | | |
| | 5.1.4 | Төрийн албаны үр ашгийг сайжруулах, ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих | Ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр тогтмол бүртгэхийн зэрэгцээ 2018.09.01-ний өдрөөс ажлаас хоцорсон болон эрт тарсан ажилтан, албан хаагчдад ногдуулах хариуцлагыг түүнд олгох ур чадварын нэмэгдэлтэй уялдуулан хасч тооцохоор болсон. Мөн цэвэрлэгээ үйлчилгээний ажилтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нэмэгдүүлэх үүднээс 2 удаа ажлын багаж сайжруулан шинэчлэх ажлыг зохион байгууллаа. | 100% | |
| | 5.2.1 | Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг шуурхай зохион байгуулж, гүйцэтгэлийн явц үр дүнд тавих хяналтыг сайжруулан, хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах | <ul style="list-style-type: none"> - Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг шуурхай зохион байгуулан, гүйцэтгэлийн явц үр дүнд тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал 23 удаа хуралдаж, ажилтан бүрийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар үүрэг даалгавар өглөө. - Захиргаа, санхүүгийн ажиллагсдын шуурхай зөвлөгөөн нийт 17 удаа хуралдаж, газрын хэмжээнд шийдвэрлэх асуудлыг шуурхай зөвлөлдөн, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг эргэн танилцуулан эргэх холбоотой ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|--|-------|--|---|------------------|--|
| | 5.2.2 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид заасан лиценз болон тусгай зөвшөөрөл, газар олгох ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон зохион байгуулах | Манай газар нь хууль тогтоомжид заасан лиценз, үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, газар олгох эрхийг олгодоггүй болно. Иймд уг заалтыг цаашид хяналтаас хасуулах саналтай байна. | Үнэлэх боломжгүй | |
| | 5.2.3 | Төрийн албаны тухай хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэн, иргэд, аж ахуйн нэгжид төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй байх | Байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг ил тод байдлын үндсэн 4 чиглэлээр www.khangardi.mn сайтад нээлттэйгээр байршуулан ажиллаж байна. Үүнд: 1. Үйл ажиллагааны ил тод байдал: - Байгууллагын эрхэм зорилго, зорилт, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм журам, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг улирал бүрээр; 2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал: - Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, тухайн жилийн сургалт мэдээллийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг байгууллагын ур чадварыг дүгнэх журмын дагуу дүгнэсэн үнэлгээ, байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа, нээлттэй ажлын байрны зарыг тухай бүр; 3. Төсөв, санхүүгийн ил тод байдал: - Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн биелэлт, хагас бүтэн жилийн санхүүгийн тайланг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байршуулсан, мөн өмнөх жилүүдийн байгууллагын | 100% | |

| | | | | | |
|--|-------|--|--|------|--|
| | | | <p>санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байршуулж мэдээлсэн; 4. Худалдан авах ажиллагааны ил тод байдал: - Байгууллагын үнэлгээний хороог байгуулсан тухай түүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан талаар мэдээлэл; - Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг улирал тутам байгууллагын цахим хуудаст байршуулж, нийтэд мэдээлсэн.</p> <p>Түүнчлэн тайлант хугацаанд газрын даргаас нийт 542 тушаал батлагдан гарснаас байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 64, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал 478 байна. Эдгээр тушаалыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.ublegal.mn цахим сайтад тухай бүр байршуулсан болно.</p> | | |
| | 5.2.4 | Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх | <ul style="list-style-type: none"> - Хариуцсан ажил үүрэгтээ хайнга хариуцлагагүй хандсан, ёс зүйн зөрчил дутагдал гаргасан нийт 17 ажилтанд Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурал болон Ёс зүйн зөвлөлийн хурлаас сахилгын шийтгэл ногдуулах санал гарч 8 ажилтан, албан хаагчид сануулах, 6 ажилтан, албан хаагчид үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар бууруулах, 3 ажилтан, албан хаагчтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах сахилгын шийтгэл ногдуулжээ. - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын дагуу төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг хагас, бүтэн жилээр гарган НЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэн ажиллаж байна. | 100% | |

| | | | | | |
|---|-------|--|--|------|--|
| | 5.2.5 | Удирдлага, ажилтнуудын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, хариуцлагатай холбож ажиллах | - Ажилтан, албан хаагчдын ажлын уг чадварыг үнэлэх ажлыг улирал бүр зохион байгуулан ажиллаж буй бөгөөд уг ажлын хэрэгжилтийн талаар Засгийн газрын 2018 оны 32 дугаар тогтоолын хэрэгжилтийн хэсэгт дэлгэрэнгүй дурдсан болно. | 100% | |
| Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай 2018.07.09 2018_01 | 2.1.1 | Төрийн байгууллагуудад хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа сэдвүүдээр сургалт, сонсголыг тогтмол зохион байгуулах, бүх байгууллагуудад “Эцэг эхийн зөвлөл” байгуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллуулах | - Газрын даргын А/53 дугаар тушаалаар НҮГ-ын “Эцэг эхийн зөвлөл”-ийг байгуулсан. - 2018.09.22-ны өдөр газрын нийт ажилтан, албан хаагчид гэр бүлийн хамт Чингэлтэй ууланд авирч, “Эцэг – эх – хүүхэд” өдөрлөг зохион байгууллаа. - Мөн мэдээллийн булан ажиллуулж, хүүхэд хамгааллын асуудлаар шаардлагатай мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. | 100% | |
| | 2.1.2 | Албан тушаалтны сахилга хариуцлагыг өндөржүүлж, хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, дотоод, гадаад орчинд эрсдлийн үнэлгээ хийж, хүүхдийн асуудлаар ямар нэгэн алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж | - Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Нийслэлийн засаг захиргааны байруудын ойр орчмын эрсдэлтэй хэсгүүдийг тодорхойлж, ил гарсан цахилгааны утсыг далдалж, унаж бэртэж болзошгүй замын саадыг арилган тэгшилж, тохижуулан, зам талбайн аюулгүй байдлыг хангасан. Мөн Нийслэлийн засаг захиргааны бүх байруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэний гарцтай болсон. | 100% | |

| | | | | | |
|---|-------|---|---|------|--|
| | | байх. | | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал | | | | | |
| Ажлын хэсэг байгуулах тухай /Аймаг, сум, дүүрэгт хууль тогтоомж зөрчсөн, зөрчил дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан, авлига, хээл хахуулийн хэрэгт холбогдсон, хүнд суртал гаргасан, ажлын байран дээр архидан согтуурсан, хадгалсан албан тушаалтантай/ 2018.08.31 2018_255 | 2.3.3 | Байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ | Газрын даргын 2018 оны А/11, А/31 дүгээр тушаалаар ажил, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталж, албан тушаал бүрийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн, гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгон, давхардал, хийдлийг арилгахыг зорин ажиллаж байна. Мөн үйлчилгээний ажилчдыг чадваржуулах үүднээс 18 удаагийн сургалтад давхардсан тоогоор 400 орчим ажилтныг хамруулж, 38 үйлчлэгчийг мэргэжлийн үнэмлэхтэй ажилтан болгосон. | 100% | |
| | 2.3.4 | Төрийн жинхэнэ албан хаагчийг томилохдоо хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, үйл ажиллагааны үр дүнг харгалзсан эсэх, хуулиар хүлээсэн үүрэг, ажлын байр /албан тушаал/-ны шалгуур шаардлагыг хангалтгүй биелүүлсэн албан хаагчдад хариуцлага оногдуулсан байдал | Нээлттэй ажлын байранд шинээр ажилтан, албан хаагчийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, газрын хөдөлмөрийн дотоод журмыг баримтлан, ажил горилогчийн ажлын дадлага туршлага, мэргэжил боловсрол, тухайн чиглэлээр мэргэшсэн байдал, харилцаа хандлага зэргийг харгалзан сонгон шалгаруулж байна. Тайлант хугацаанд жирэмсний болон амаржсаны амралттай байгаа 15, гурван сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж байгаа 1, эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны чөлөөтэй байгаа 4, өндөр насны тэтгэвэрт гарсан 5, ажлаас чөлөөлөгдсөн 23 ажилтан, албан хаагчийн оронд 45 ажилтан, албан хаагчийг шинээр сонгон шалгаруулж, хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллуулж байна. | 100% | |
| | 2.3.5 | Төрийн албан хаагчтай | Ажилтан, албан хаагчийн гаргасан ёс зүйн зөрчлийг | 100% | |

| | | | | | |
|--|-------|--|--|------|--|
| | | холбоотой гэмт хэрэг, зөрчил, сахилга ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тогтоон, сахилга, ёс зүйн зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнд хүрэхүйц ажил зохион байгуулсан байдал | байгууллагын Ёс зүйн хорооны хурлаар хэлэлцүүлж, тухай бүр зохих арга хэмжээ авч ажилласнаар 2018 оны эхний хагас жилд 14 ажилтан, албан хаагчийн ёс зүйн зөрчил бүртгэгдсэн бол сүүлийн хагас жилд энэ тоон мэдээ 3 болж, эхний хагас жилийн мэдээнээс 5 дахин буурсан эерэг үзүүлэлттэй байна. Энэ нь байгууллагын ёс зүйн зөвлөл болон удирдлагын зүгээс хариуцсан ажил үүргээ сайтар биелүүлж, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж буйн үр дүн юм. | | |
| | 2.3.6 | Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, байгууллагын дотоод дүрэм, журамд тусган мөрдүүлж ажилласан байдал | Газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйл, Ёс зүйн журмын 3, 4 дүгээр зүйлд хууль бус дарамт шахалт үзүүлэх, ялгаварлан гадуурхах байдлыг хориглосон зохицуулалт оруулж, уг үйлдлийг удаа дараа давтан гаргасан ажилтан, албан хаагчид ажлаас чөлөөлөх хүртэл сахилгын шийтгэл ногдуулахаар тусгасан. Тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил дутагдал гаргаагүй нь уг журам бүрэн хэрэгжиж буйн илрэл юм. | 100% | |
| | 2.3.7 | Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлд ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, хэрэглэсэн үедээ ирсэн болон ажил үүрэг гүйцэтгэсэн, мөн галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг ажлын байранд нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хатуу хориглож, ийм үйлдэл гаргасан ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг Ажил олгогчийн санаачилгаар шууд цуцлахаар тусгасан болно. Тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил бүртгэгдээгүй байна. | 100% | |

| | | | | | |
|--|--------|---|--|------|--|
| | | бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусгасан байдал | | | |
| | 2.3.8 | Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалт, сонор сэрэмжийг дээшлүүлэх, гарч болзошгүй аливаа эрсдлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан байдал. | Долоо хоногийн амралтын өдрүүд болон нийтээр амрах баярын өдрүүдэд нийслэлийн засаг захиргааны байруудад ажиллах хариуцлагатай эргүүлийг газрын даргын А06, А/40, А/58 тушаалаар 3 удаа томилон ажиллууллаа. Хариуцлагатай эргүүл нь нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянах, гарч болзошгүй гал, усны аюул ослоос урьдчилан сэргийлэх, гарсан зөрчил доголдлыг даруй зохицуулж, харуул хамгаалалтын ажилтан болон инженер техникийн ажиллагсадтай нягт холбоотой ажиллах чиг үүрэгтэй бөгөөд тухайн томилогдсон хариуцлагатай эргүүлийн зүгээс зөрчил доголдлыг тухай бүр арилгаж, урьдчилан сэргийлж ажилласан байна. | 100% | |
| | 2.3.9 | Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон албан хаагчид хариуцлага тооцсон эсэх, сахилгын шийтгэлийг ажлаас халах хүртэл хүндрүүлэн оногдуулсан байдал | Тайлант хугацаанд энэ төрлийн зөрчил гараагүй болно. | 100% | |
| | 2.3.10 | Нутаг дэвсгэртээ архидан согтуурахтай тэмцэх, архины хор уршгийг олон нийтэд | Нийслэлийн засаг захиргааны байруудад архидан согтуурахыг хатуу хориглож, архины хор уршгийг олон нийтэд таниулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг | | |

| | | | | | |
|--|--------|---|--|------------------|--|
| | | таниулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагыг дэмжиж, хамтран ажилласан байдал | төрийн болон төрийн бус байгууллауудын үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. | | |
| | 2.3.11 | Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээний цагийн хязгаарыг аймаг, сумын хэмжээнд шинэчлэн тогтоосон байдал | Энэхүү зохицуулалт нь манай байгууллагын чиг үүрэгт хамааралгүй тул цаашид хяналтаас хасуулах саналтай байна. | Үнэлэх боломжгүй | |
| | 2.3.12 | Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн бүртгэл, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байдал | Тайлант хугацаанд байгууллагад ирсэн 230 өргөдөл гомдлыг өргөдөл гомдлын нэгдсэн системд бүртгэсэн даруй хариуцах албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлүүлж, хариуг тус системд тухай бүр байршуулан ажилласан. 2018 онд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 4 хоног, 11 цаг, 25 минут байгаа нь өмнөх жилийн мөн үеийнхээс 2 хоног 7 минутаар, өргөдөл гомдлын хандалтын тоо 21 хувиар буурсан байна. Мөн тайлант хугацаанд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн болон хугацаа сунгуулж шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. | 100% | |
| | 2.3.13 | Төрийн албан хаагчийн ажлын цаг ашиглалт, үр дүнг дүгнэж ажилласан байдал | Ажилтан, албан хаагчдын ажлын цагийн бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр бүртгэн, 2018.09.01-ний өдрөөс ажлаас хоцорсон болон эрт тарсан ажилтан, албан хаагчдад ногдуулах хариуцлагыг түүнд олгох ур чадварын нэмэгдэлтэй уялдуулан хасч тооцохоор болсон. Мөн ажлын | 100% | |

| | | | | | |
|--|--------|--|---|------|--|
| | | | байранд үүрэгт ажлаа чанартай үр дүнтэй гүйцэтгэж буй эсэхэд Дотоод хяналт–шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажилтнаас тогтмол хяналт тавин ажиллаж буй болно | | |
| | 2.3.14 | Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх | Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/142 дугаар захирамжаар нийслэлийн засаг захиргааны байруудын засварын ажлыг зохион байгуулах эрхийг НҮГ-т шилжүүлсэн. Уг захирамжийн дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 33.1, 33.2-т зааснаар техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа 3 ба түүнээс дээш хуулийн этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдсэн ба уг мэдэгдлийн дагуу үнийн санал ирүүлсэн хуулийн этгээдээс мөн хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн “Мөнгөн Оройт Цамхаг” ХХК, “Дус Монголиа” ХХК, “Сагсай Өргөө” ХХК, “Модерн Хийц” ХХК-иудад гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн. Шалгарсан гүйцэтгэгчид нь захиалгат ажлыг НХОГ-тай байгуулсан гэрээний хугацаанд бүрэн гүйцэтгэж, ажлын гүйцэтгэлийг томилогдсон комиссод хүлээлгэн өгсөн байна. | 100% | |
| | 3.1 | Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”, Засгийн газрын 2018 оны 08 | Манай байгууллага нь Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолын заалт бүрийн хэрэгжилтийг ханган ажиллахын зэрэгцээ тайланг сарын бүрийн 05-ны өдрийн дотор | 100% | |

| | | | | |
|--------------------------|---|--|--|--|
| | дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг заалт бүрээр гаргах, хэрэгжилтийг хангуулаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох | НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. | | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | |
| Нийт дундаж: 99,8 хувь | | | | |

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.ХОРОЛДУЛАМ